

## 2 ИОХАН

<sup>1</sup>Ахлагчаас сонгогдсон эзэгтэй болоод түүний хүүхдүүдэд: Миний, зөвхөн миний биш, бас үнэнийг мэддэг бүгдийн та нарыг үнэн дотор хайрладаг нь <sup>2</sup>бидний дотор байгаа бөгөөд бидэнтэй үүрд хамт байх үнэний төлөө юм. <sup>3</sup>Эцэг Бурхан ба Эцэгийн Хүү Есүс Христээс ирсэн нигүүлсэл, өршөөл, амар тайван нь үнэн хийгээд хайрын дотор бидэнтэй хамт байх болно.

<sup>4</sup>Эцэгээс бид тушаал хүлээн авсан шиг таны хүүхдүүдийн зарим нь үнэний дотор явж буйг мэдсэндээ би их баярласан. <sup>5</sup>Эзэгтэй, бие биеэ хайрлахыг эдүгээ би танаас гүйж байна. Үүнийг шинэ тушаал болгон танд бичиж байгаа бус, харин эхнээсээ энэ нь бидэнд байсан билээ. <sup>6</sup>Бид Түүний тушаалуудын дагуу явцгаая. Энэ бол хайр билээ. Та нар эхнээсээ сонссончлон түүний дотор явах нь тушаал юм. <sup>7</sup>Олон мэхлэгчид ертөнцөд орж ирсэн. Тэд Есүс Христийг махан биеэр ирснийг хүлээн зөвшөөрдөггүй ажээ. Энэ бол мэхлэгч бөгөөд Христийг эсэргүүцэгч мөн. <sup>8</sup>Та нар бидний гүйцэлдүүлснийг алдалгүй, харин дүүрэн шагналыг хүлээн авахын тулд өөрсдийгөө хяна. <sup>9</sup>Хэтэрч, Христийн сургаал дотор байдаггүй хэнд ч Бурхан байхгүй. Сургаал дотор байгч нэгэнд Эцэг ч, Хүү ч байна. <sup>10</sup>Хэрэв хэн нэгэн нь та нар уруу ирэхдээ энэ сургаалыг авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул. Түүнтэй мэндэлж болохгүй. <sup>11</sup>Түүнтэй мэндэлж буй хүн нь түүний бузар үйлсэд оролцож байгаа хэрэг юм.

<sup>12</sup>Та нарт бичмээр зүйл надад олон байгаа ч би цаас янтай нийлүүлэхийг хүсэлгүй, харин та нар уруу очиж, нүүр нүүрээрээ ярилцана гэдэгт найдаж байна. Ингэснээр бидний баяр хөөр дүүрэн болно. <sup>13</sup>Таны сонгогдсон эгч дүүгийн чинь хүүхдүүд, танд мэнд хүргэж байна.